

БҮСИЙН НУТГИЙН ХАНГАЛТЫН ТӨВ БААЗ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Л.Лхагвасүрэн

*Ар тал, эдийн засгийн тэнхимийн
дэд профессор, докторант, дэд
хурандаа*

Товч агуулга: Хилийн цэргийн анги салбаруудын бүх төрлийн хангалтын үйл ажиллагаа нь уламжлагдаж ирсэн цэргийн хангалтын системийн дагуу зохион байгуулж байна. Иймээс хангалтын зохион байгуулалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгарч үүний дагуу хил хамгаалах байгууллагаас 2010 оноос эрчимтэйгээр бүсчилсэн хил хамгаалалт руу шилжүүлсээр байна. Энэ нь цэргийн хангалтыг зохион байгуулах бүсийн хангалтын төв баазын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хилийн цэргийн анги, салбарт үүрэг гүйцэтгэж байгаа хилчдийн хангалтыг илүү найдвартай түргэн шуурхай олгоход чиглэх, хангалтыг илүү нарийвчлалтайгаар бүс нутагт нь тохируулан зохион байгуулахад судалгааны ажил чиглэсэн болно. Судалгааны ажлын арга зүй: Баримт материалыг цуглуулах, харьцуулах, нэгтгэн дүгнэх арга ашиглав. Судалгааны үр дүн: Судлаач миний судалгааны ажилд Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 0281, 0282, 0284 дүгээр

салбарын хариуцсан хэсэгт байрлах 3 малын суурийн 1500 гаруй малаас Ангус, Монгол, Сарлаг, Эрлийз үхрүүдийн ашиг шим, зарцуулалтын талаар харьцуулалтыг судалж, үр дүнг харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Мал, фермер, салбар, ар тал, хангалт

Удиртгал

Монгол Улсын газар зүй, нийгэм, эдийн засгийн онцлог, улсын хил дээр гарч буй зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцөлийг үндэслэн улсын хил хамгаалалтыг говь цөл, тал хээр, ой тайга, уулын болон усан гэж бүсчилсэн улсын хил хамгаалалтыг зохион байгуулах болсон. “Хилийн нөхцөл байдал байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт”(Монгол улсын хилийн тухай хууль, 2017) гэнэ гэж заасан байдаг. Монгол Улсын хил хамгаалалтыг найдвартай хамгаалахын үндсэн баталгааны нэг нь хил хамгаалах байгууллагын ар тал хангалтыг хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагааны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгах, цагийн байдал өрнөсөн үед хурдан шуурхай маневр, материал хэрэгслийн хангалтыг тасралтгүй, шуурхай хангах ар талын удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийг нарийвчлалтай

хийх явдал өнөөгийн нөхцөл байдал биднээс шаардаж байна.


Цэргийн аж ахуй гэдэг нь хилийн цэргийн анги, цэргийн ангиудын улсын хил хамгаалах үйл ажиллагаа, албаны бэлтгэл, нийт бүрэлдэхүүний материаллаг ахуй, соёлын хэрэгцээг тасралтгүй бүх талаар хангах, зэвсэг техник, галт хэрэглэл, шатахуун, бусад материал хэрэгслийг зөв ашиглах, арчлан хамгаалахад зориулагдсан материал хэрэгслийн зохих нөөц бүхий аж ахуй, техник, эмнэлгийн болон албаны бэлтгэл сургуулийн материал-техникийн бааз юм.

Цэргийн аж ахуйн үндсэн үүрэг нь хилийн цэргийн анги хил хамгаалах болон албаны бэлэн байдлыг байнга өндөр хэмжээнд байлгаж, тайван цагийнхаас онцгой байдалд түргэн шилжих бүх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан ар тал хангалтын удирдлагын төлөвлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ

Хилийн болон хил орчмын аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг удирдан зохион байгуулахад хилийн тодорхой хэсэг газрыг тодорхойлох үндсэн нутаг дэвсгэр нь бүсийн орон зай буюу тухайн нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур физик газар зүй, бүсийн онцлог, хүн амын зан заншил, мал амьтны маллагаа хариулаг, ан амьтан, нийгэм,

эдийн засгийн байдал, дэд бүтцийн хөгжил, хил худалдааны орчин зэрэг нь харилцан адилгүй байдаг тул цэргийн хангалтыг удирдан зохион байгуулахад нөлөөлөх үндсэн нөхцөл, байгаль цаг улиралд зохицсон хүнс, хувцас, хүн мал эмнэлгийн хангалт үйлчилгээ бий болгохыг шаардаж байгаа бөгөөд дараах бүсүүдэд хуваан авч үзэж байна. Цэргийн хангалт, цэргийн аж ахуйг удирдан зохион байгуулна түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх нь Хилийн цэргийн алба хаагчдын нийгмийн баталгаа нэмэгдүүлж алба хаах таатай орчныг бүрдүүлэх үндсэн гол чиглэл болж байдаг ийм тулд Хилийн цэргийн анги салбарт байгаа малын суурийн малын ашиг шим гарцыг судлахад дараах байдлаар ажиглагдаж байна. Үүнд нь Монгол үхрийн махыг ангус, эрлийз үхэр, сарлаг, монгол үхэр зэргийг харьцуулан судаллаа



Зураг №1. Монголын малын бүтээгдэхүүний гарц

Өсөлтийн зарим дундаж үзүүлэлтийг дурдвал: эр Ангус 33 кг жинтэй төрж, 200 хоногийн дотор 250 кг, 365 хоногийн дараа 380 кг жинтэй, эм нь 30 кг жинтэй төрж, 200 хоногт 230, 365 хоногт 330 кг болно. Нас бие гүйцсэн бух 800-1100 кг, үнээ 550-700 кг татах ба сэрвээний өндөр нь бух 135-150, үнээ 120-140 см.

Монгол үүлдрийн үхрийн биеийн жин тухайн жилийн өвөлжилт, зуншлагын байдлаас хамааран харилцан адилгүй байдаг ч дунджаар ойт-хээрийн бүсэд нас гүйцсэн бух 360-400 кг, үнээ 280-320 кг, эр шүдлэн 200-230 кг, охин шүдлэн 180-200 кг, эр бяруу 140-170 кг, тугал эхээс төрөхдөө 16-18 кг, 6-7 сартайд 70-100 кг байна. Алтайн уулархаг нутаг, говийн бүсийн монгол үхэр арай бага жинтэй, Дорнод,

Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн үхэр бусад нутгийнхаас 15.0-20.0 хувь илүү жинтэй байна.

Шахаж бордсон үхрийн нядалгааны гарц 65-70%. Яс нимгэнтэй учраас гулуузан дахь ясны харьцангуй хувь 15-18%-с хэтэрдэггүй. Махны чанарын үзүүлэлтээр дээд зэрэгт тооцогддог. Булчингийн ширхэг нарийхан, махны алаглалаар Шортгорн, Герефорд үхрээс ч илүү юм.

Тал хээрийн бүс: Хилийн ... отряд ... застав, харуулын хариуцсан км хэсэг буюу улсын хилийн 22.5 хувь хамрагдана.

Говь цөлийн бүс: Хилийн отряд, застав, харуулын хариуцсан км хэсэг буюу улсын хилийн 26,0 хувь хамрагдана.

Уулын бүс: Хилийн.... отряд, застав, харуулын хариуцсан

..... км хэсэг буюу улсын хилийн 24,0 хувь хамрагдана.

Ой тайгын бүс: Хилийн ...отряд, ... застав, харуулын хариуцсан км хэсэг буюу улсын хилийн 27,5 хувь хамрагдана.

Дээрх бүсүүдийг Удирдах газрууд “Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан” (Монгол улсын хилийн тухай хууль, 2017) тухайн бүс нутагтаа аж үйлдвэрлэл хөгжсөн, хамгаалж буй хэсгийнхээ аль болох төвд байрласан аймгуудыг сонгон авч бүсийн хангалтын баазыг байгуулах шаардлагатай байна.

а. Уулын бүсийг удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Ховд аймагт

б. Ой тайгын бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Дархан-Уул аймагт

с. Говь цөлийн бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Өмнөговь аймагт

д. Тал хээрийн бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Дорнод аймаг зэрэг аймгуудад байгуулахын бол хангалтын тасралтгүй шуурхай байдал улам сайжрахаас гадна,

шатахууны урсгал зардлыг ч хэмнэх боломжтой, хөрш орнуудын хил хамгаалах салбартай ижил хэмжээнд очиж, хил хамгаалалтын бодит үр дүн бий болно гэж үзэж байна.

Дээрх аймгуудад байгуулагдсан бүсийн удирдах газрын харьяа бүсийн хангалтын төв бааз нь биеэ даасан үйл ажиллагаа явуулан хилчдийн хангалтыг зохион байгуулахаас гадна тухайн байрлаж байгаа орон нутагтаа үйлдвэрлэгч болох хөрш отряд заставуудаа чанартай бүтээгдэхүүнээр хангах боломжтой гэж үзэж байна.

Жишээ нь: Сэлэнгэ аймаг нь газар тариалан голлон хөгжүүлсэн аймаг юм. Манай орны газар тариалангийн талбайн үлэмж хэсэг энэ аймгийн нутагт Орхон Сэлэнгийн савд төвлөрсөн юм. Улсын үр тарианы 40 орчим хувийг үйлдвэрлэдэг, 570,000 гаруй малтай. Сэлэнгэ аймагт мод боловсруулах, гурилын, хүнсний, спирт бал бурамын үйлдвэр, вагон засварын газар бий. Сүхбаатар хот нь төмөр ба авто замын гол зангилаа нутаг бөгөөд манай хилийн байнгын чухал гарцын нэг юм.

Тэгвэл Ой тайгын бүсийн хангалтын төв бааз нь энэ аймаг, орон нутаг болон хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангиудыг түшиглэн бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн мал аж ахуй руу шилжин махны чиглэлийн ангус үйлдвэрийн үхрийг үржүүлэн хөрш хилийн отрядууд,

хилчдийг хангахаас гадна орон нутагт чанартай хүнсний бүтээгдэхүүн зэргийг нийлүүлэх дотоод орлого бүрдүүлэх боломжтой юм.

Ангус үүлдрийн Шотландаас гаралтай энэ үүлдэр нь дэлхий дээр хамгийн их тархсан махны чиглэлийн шилмэл үүлдрийн нэг. Мөн дэлхий дээр анхнаасаа махны чиглэлээр дагнаж үржүүлсэн цорын ганц үүлдэр юм. Төрөлх өнгө нь хар боловч сүрэг дунд улаан өнгийн үхэр мэр сэр байх нь түгээмэл. Ангус үхэр бие даасан үүлдэр болж үүссэн 19-р зууны үед хар өнгө "моод"-нд орж байсан тул улаан өнгөтэй үхрийг тусад нь үржүүлсэнгүй, харин ч гадуурхах маягтай байв. Харин АНУ-д 1945 оноос улаан Ангус үхрийг тусад нь үржүүлж эхэлсэн байна. Ангус үхэр мухар, түргэн өсөлттэй, лагс биетэй, өргөн гүн цээжтэй, чац богиной, толгой хөнгөн, хүзүү өргөн, богино, булчин их сайн хөгжсөн, хонгоны булчин борвио хүртэл унжсан, нимгэн, зөөлөн үсээр бүрхэгдсэн сийрэг арьстай. Өсөлт түргэнтэй нь хэдийгээр нэг талаар ашигтай боловч нөгөө талаар өөхлөлт эрт явагддаг сөрөг үр дагавартай.

Энэ мэтчилэн бүс тус бүр дээр байгуулагдсан хангалтын төв бааз нь өөрийн бүсэд байгаа хилийн отряд, заставынхаа хангалтыг хурдан шуурхай зохион байгуулахаас гадна, тухайн орон нутгийнхаа давуу байдлыг ашиглан орлого олох, олсон

орлогоосоо хилийн застав, харуулын албаны байр, орон сууцыг засварлах тохижуулах, тог цахилгаангүй харуул, заставын шатахууны хангалтыг нэмж хангах ч боломжтой юм.

Хилийн отрядад ажиллаж байгаа офицер, ахлагч нар хүнс авдаггүй ба бүсийн хангалтын төв бааз нь хөндөлттэй үнээр тухайн хилийн отрядын алба хаагчдад мах, гурил, сүү өөрсдийн орлого олж байгаа бүтээгдэхүүнээ зарах зэрэг олон ашиг тус бий болно.

Хилчид бид бүхэн өөрсдийн хэрэгцээгээ хангахаас гадна үйлдвэрлэгч, бүтээгч болох бүрэн боломжтой байна.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын ар тал хангалтыг бүсийн хангалтын бааз дээр тулгуурлан зохион байгуулах юм бол хангалтын хурдан, шуурхай байдал нэмэгдэхээс гадна жилийн урсгал зардлаас хэмнэх боломжтой байна. Энэ мэтчилэн хангалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулбал маш олон зүйлийг хэмнэх давуу талтайгаас гадна зарим хангагдаагүй бүтээгдэхүүнээр ч хилчдийг хангах бодит боломж бий болно гэж үзэж байна.

Судалгаанд бүсийн хангалтын төв бааз байгуулах нь зөвхөн нутгийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхээс гадна Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 0281, 0282, 0284 дүгээр салбаруудын хил хамгаалалтын бэлэн байдлыг хангах, хээрийн

хангалтын найдвартай эх үүсвэр бий болгох, мал аж ахуйн ашиг шимийг хил орчмын орон

нутгийн хөгжилд түлхүү хувь нэмэр оруулах үндсэн нөхцөл болохыг харуулсан юм.

Цаашид төвийн хангалтын бааз нь зөвхөн хангалт зохион байгуулахаас гадна, орлого олох томоохон зах зээлийн тоглогч болох болно.

Санал

Монгол Улсын хилийн тухай хуулийн 34.3 дахь заалтын дагуу Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан Засгийн газар тогтооно гэсэн заалтын дагуу Бүсийн удирдах газар болон дэргэд нь Бүсийн хангалтын төв бааз байгуулах

- Хилийн отрядын мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй руу шилжүүлэн орон нутагт өөрсдөө орлого олох боломжийг бүрдүүлэх зэрэг саналтай байна.

Эх сурвалж:

Баттөр, Б., & Эрдэнэчимэг, С. (2022). Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн ашиг шим. *Монголын агро шинжлэх ухааны сэтгүүл*, 34(2), 55-63.

Баярмаа, Н., & Жаргал, Р. (2020). Мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах нь. *Монгол улсын мал аж ахуйн сэтгүүл*, 12(1), 35-45.

Баттулга, Б. (2022). Хилийн ангиудын эрүүл мэндийн менежмент, түүний асуудлууд. Улаанбаатар: Батлан хамгаалах их сургууль.

Батлан хамгаалахын логистикийн агентлаг. (2022). 2022 оны жилийн тайлан. <https://www.dla.mil> сайтаас авсан.

Болд, Д. (2021). Ангус болон Монгол үүлдрийн үхрийн үйлдвэрлэлийн харьцуулалт. *Азийн тивийн мал аж ахуйн судалгаа*, 29(4), 122-130.

Гантулга, С. (2022). Монгол малын генетик судалгаа болон үржлийн сайжруулалт. *Мал аж ахуйн шинжлэх ухаан*, 18(3), 78-89.

Ганболд, Н. (2023). Хилийн хамгаалалтын судалгааны судалгаа. Улаанбаатар: Үндэсний батлан хамгаалахын их сургууль.

Дорж, Т., & Батсүх, Т. (2023). Үүлдрийн ашиг шимийг сайжруулах стратеги. *Мал аж ахуйн судалгааны сэтгүүл*, 45(1), 15-23